



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Эрдэнэбүрэн сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: ХОА-2026/017/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Ховд хот 2026 он	Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас: 70432545 Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn Аудитор: Н.Ариунтуяа Утас: 94004399 Цахим хаяг: <a href="mailto:ariuntuyan@audit.gov.mn">ariuntuyan@audit.gov.mn</a>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

<b>1. АУДИТЫН ДҮГНЭЛТ</b> .....	<b>2</b>
<b>2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ</b> .....	<b>5</b>
2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	5
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	6
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	7
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	8
<b>3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ</b> .....	<b>8</b>
3.1 Төлбөрийн акт .....	9
3.2 Зөвлөмж.....	9
<b>4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ</b> .....	<b>12</b>
<b>5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл</b> .....	<b>13</b>

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль

## 1. АУДИТЫН ДҮГНЭЛТ



### ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд аймаг  
Утас/Факс: (976)-7043-3061  
Email: khovd@audit.gov.mn

2026.03.25 № 178

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ЭРДЭНЭБҮРЭН СУМЫН ТӨСВИЙН  
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ  
Ц.АЛТАНГЭРЭЛ ТАНАА

#### Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Эрдэнэбүрэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь санхүүгийн тайланд материаллагаар нөлөөлсөн бөгөөд өргөн тархсаныг хангалттай, зохистой аудитын нотолгоонд үндэслэн нотолсны улмаас Эрдэнэбүрэн сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулаагүй гэж үзсэн.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн доорх зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4, 13 дугаар зүйлийн 13.1, 13.6, 13.7, 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.1, 20 дугаар зүйлийн 20.2.5, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16.5.1, 16.5.2, 16.5.4, Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалын хоёр дугаар зүйлийн 3-дах заалтуудтай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна. Үүнд:

- ✓ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хөтөлбөр, мал амьтны халдварт өвчинтэй тэмцэх зардлыг малын тоо толгойн албан татварын орлогоос хувь иргэний данс ашиглан анхан шатны баримтыг зөрүүтэй бүрдүүлэн 16,000.0 мянган төгрөгийг бэлнээр гаргуулан авсан,

84761196-3

- ✓ Аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон 4 гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй хийсэн ажлын тайлан болон төсвийн задаргаагүй хүрсэн үр дүн тодорхойгүй, гүйцэтгэлд үндэслэн санхүүжилт олгоогүй 6,600.0 мянган төгрөг,
- ✓ Няравын дансаар болон хувь хүний дансаар дамжуулан хөтөлбөр арга хэмжээнд 10,110.0 мянган төгрөгийг зарцуулсан нь анхан шатны баримт дутуу, хэрхэн зарцуулсан нь тодорхойгүй, мал тооллогоор зарцуулсан шатахууныг орлогод бүртгэж бараа материалын тайланд тусгаагүй 1,815.0 мянган төгрөг зарцуулсан,
- ✓ Насжилт өндөртэй авлагыг барагдуулаагүй 18,779.0 мянган төгрөгийн зөрчлүүд байна.

#### **Асуудлыг онцолсон хэсэг**

Эрдэнэбүрэн сум нь 2025 оны байдлаар 2,267 хүн амтай, 103 төрийн албан хаагчтай, 680 өрхтэй, 459 малчин өрхтэй, 117 мал бүхий өрх, малчинтай, жилийн эцсийн мал тооллогоор 146,657 толгой мал тоолуулжээ.

#### **Аудитын гол асуудал**

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Эрдэнэбүрэн сум нь татварын болон татварын бус орлогоор нийт 524,573.6 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, орлогыг 11,649.9 мянган төгрөг буюу 102.3 хувиар давуулан бүрдүүлсэн байна.

Материаллаг буруу эрсдэлийн үнэлгээ өндөр анхаарал татсан асуудлыг дүгнэлтийн үндэслэл хэсэгт тусгасан болно.

#### **Бусад асуудлын хэсэг**

Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт үндсэн 5 хөтөлбөрийн хүрээнд 16 дэд бүлгийн 150 заалтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөн биелэлтийг 91.4 хувиар дүгнүүлэн ажилласан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>524,141.69</b>	<b>703,083.88</b>
2	1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ	263,449.14	402,692.92
3	1.1.3 АВЛАГА	198,923.74	223,165.06
4	1.1.4 УРЬДЧИЛГАА	0.0	40,000
5	1.1.5 БАРАА МАТЕРИАЛ	61,768.81	37,225.9
<b>6</b>	<b>1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>2,426,923.24</b>	<b>2,809,509.44</b>
7	1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,426,923.24	2,809,509.44
8	1.2.2.02 Биет хөрөнгө	2,402,417.04	2,785,003.24
9	1.2.2.03 Биет бус хөрөнгө	24,506.2	24,506.2
<b>10</b>	<b>1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>2,951,064.92</b>	<b>3,512,593.32</b>
<b>11</b>	<b>2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>5,172.21</b>	<b>20,505.64</b>
12	2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	5,172.21	20,505.64
13	2.1.1.03 Өглөг	5,172.21	20,505.64
<b>14</b>	<b>2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>2,945,892.72</b>	<b>3,492,087.68</b>
15	2.2.1 Засгийн газрын хувь оролцоо	2,945,892.72	3,492,087.68
16	2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал	609,081.17	609,081.17
17	2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн	2,107,730.15	2,653,925.12
18	2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	229,081.39	229,081.39
<b>19</b>	<b>2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>2,951,064.92</b>	<b>3,512,593.32</b>

### 2.2 Аудит хийсэн нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>2,553,812.71</b>	<b>2,981,351.32</b>
<b>2</b>	<b>1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>518,416.46</b>	<b>522,804.96</b>
3	1.1.1.03.1 Орлогын албан татвар	368,482.38	353,411.63
4	1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар	391,399.83	386,138.17
5	1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-22,917.45	-32,726.53
6	1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	56,859	64,380.16
7	1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	93,075.07	105,013.17
8	1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	161,382.04	2,458,546.36
9	1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,575,961.81
10	1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,874,014.21	0.0
<b>11</b>	<b>1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,476,087.4</b>	<b>2,438,293.97</b>
<b>12</b>	<b>1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>2,476,087.4</b>	<b>2,438,293.97</b>
13	1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,179,567.6	2,376,982.15
14	1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	763,672.01	898,985.83
15	1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	94,346.04	112,284.18
16	1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	507,689.51	518,162.3
17	1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	364,029.66	505,450.66
18	1.1.2.01.1.05 Нормативт зардал	496.2	0.0
19	1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	10,478.8	10,378.5
20	1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	8,239.8	7,587.6
21	1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	147,630.7	61,955.08
22	1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	282,984.89	262,178.01
23	1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	296,519.8	61,311.82
<b>24</b>	<b>1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>77,725.3</b>	<b>543,057.35</b>
<b>25</b>	<b>1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>3,316.67</b>	<b>10,069.89</b>

26	1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-3,316.67	-10,069.89
27	1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	74,408.64	532,987.46

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	2,467,556.91	2,394,934.12
2	1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО	518,416.46	522,804.96
3	1.1.1.1.03.1 Орлогын албан татвар	368,482.38	353,411.63
4	1.1.1.1.03.1.02 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-22,917.45	-32,726.53
5	1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар	56,859	64,380.16
6	1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж	93,075.07	105,013.17
7	1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж	24,052.5	22,210.6
8	1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр	1,879.57	3,126.17
9	1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр	67,143	79,676.4
10	1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО	75,126.24	1,872,129.16
11	1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого	75,126.24	40,576.35
12	1.1.1.1.04.3 Тусламжийн орлого	0.0	1,575,961.81
13	1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0.0	255,591
14	1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,874,014.21	0.0
15	1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,860,140.78	1,725,657.19
16	1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ	1,860,140.78	1,725,657.19
17	1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,565,123.98	1,664,345.37
18	1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	761,610	890,248.56
19	1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	95,198.6	118,037.6
20	1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	507,689.51	524,214.67
21	1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал	26,607.04	36,894.7
22	1.1.1.2.01.1.05 Нормативт зардал	553.7	0.0
23	1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал	7,678.8	10,378.5
24	1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал	8,239.8	7,587.6
25	1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,908.67	41,039
26	1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал	96,637.86	35,944.74
27	1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	295,016.8	61,311.82
28	1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	607,416.13	669,276.93
29	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	437,115.67	490,033.15
30	1.1.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	437,115.67	490,033.15
31	1.1.2.01.1 Дотоод эх үүсвэрээр	437,115.67	490,033.15
32	1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-437,115.67	-490,033.15
33	1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	35,000	40,000
34	1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-35,000	-40,000
35	1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	135,300.46	139,243.78
36	1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	128,148.68	263,449.14
37	1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	263,449.14	402,692.92

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,920,484.08	2,920,484.08
2	1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-49,000	-49,000
3	1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,871,484.08	2,871,484.08
4	1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн	74,408.64	74,408.64
5	1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,945,892.72	2,945,892.72
6	1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	2,945,892.72	2,945,892.72
7	1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,945,892.72	2,945,892.72
8	1.3 Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	13,207.5	13,207.5
9	1.7 Тайлант үеийн үр дүн	532,987.46	532,987.46
10	1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,492,087.68	3,492,087.68

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Мянган төгрөгөөр

Дансны код	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>3.1.01.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>2,098,288.5</b>	<b>2,111,141.11</b>
<b>11</b>	<b>3.1.01.1.1 Татварын орлого</b>	<b>511,923.7</b>	<b>522,804.96</b>
110	3.1.01.1.1.1 Орлогын албан татвар	353,385.9	353,411.63
1100	3.1.01.1.1.1.1 Хувь хүний орлогын албан татвар	386,112.4	386,138.17
1101	3.1.01.1.1.1.2 Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-32,726.5	-32,726.53
113	3.1.01.1.1.1.3 Хөрөнгийн албан татвар	51,153.4	64,380.16
118	3.1.01.1.1.8 Бусад татвар, төлбөр, хураамж	107,384.4	105,013.17
1180	3.1.01.1.1.8.1 Бусад нийтлэг төлбөр, хураамж	27,890	22,210.6
1181	3.1.01.1.1.8.2 Газрын төлбөр	5,134.4	3,126.17
1182	3.1.01.1.1.8.3 Байгалийн нөөц ашигласны төлбөр	74,360	79,676.4
<b>12</b>	<b>3.1.01.1.2 Татварын бус орлого</b>	<b>1,586,364.8</b>	<b>1,588,336.15</b>
120	3.1.01.1.2.1 Нийтлэг татварын бус орлого	21,605	23,576.35
122	3.1.01.1.2.3 Тусламжийн орлого	1,309,168.8	1,309,168.8
123	3.1.01.1.2.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	255,591	255,591
<b>II</b>	<b>3.1.01.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>2,300,919.10</b>	<b>1,937,415.49</b>
<b>21</b>	<b>3.1.01.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,775,843.80</b>	<b>1,704,123.72</b>
210	3.1.01.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,754,832.8	1,642,811.9
2101	3.1.01.2.1.1.1 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	948,501.8	890,248.56
2102	3.1.01.2.1.1.2 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,562.9	118,037.6
2103	3.1.01.2.1.1.3 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	547,475.4	524,214.67
2104	3.1.01.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	27,246.5	19,613.5
2105	3.1.01.2.1.1.5 Нормативт зардал	683.20	-
2106	3.1.01.2.1.1.6 Эд хогшил, урсгал засварын зардал	12,836.6	10,378.5
2107	3.1.01.2.1.1.7 Томилолт, зочны зардал	9,913.6	7,587.6
2108	3.1.01.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	51,322.2	39,786.74
2109	3.1.01.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	38,290.6	32,944.74
213	3.1.01.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	21,011.0	19,470.00
2131	3.1.01.2.1.4.1 Засгийн газрын урсгал шилжүүлэг		0.0

2132	3.1.01.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	21,011.00	19,470.00
22	<b>3.1.01.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>485,075.3</b>	<b>235,133.59</b>
23	<b>3.1.01.2.3 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	<b>40,000</b>	<b>40,000</b>
8	<b>3.1.01 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>(202,630.60)</b>	<b>131,883.81</b>
9	3.1 АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	202,630.60	-131,883.81
7	3 Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	202,630.60	-131,883.81
4	<b>4 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	<b>263,449.14</b>
5	<b>5 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	<b>402,650.12</b>

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөгөөр)

Дансны код	Дансны нэр, төрөл	2024.12.31	2025.12.31
1	<b>1.1.1.1 НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>67,784.54</b>	<b>30,778.70</b>
12	<b>1.1.1.1.1 ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>67,784.54</b>	<b>30,778.70</b>
122	1.1.1.1.1.1 Тусламжийн орлого	67,784.54	30,778.70
1221	1.1.1.1.1.1.1 Хандив тусламж /дотоод/	67,784.54	30,778.70
12213	1.1.1.1.1.1.1.1 Нэмэлт санхүүжилтийн орлого	67,784.54	30,778.70
II	<b>1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>67,784.54</b>	<b>458,875.62</b>
21	<b>1.1.1.2.1 УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>67,784.54</b>	<b>297,787.62</b>
210	1.1.1.2.1.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	41,748.24	283,412.62
2104	1.1.1.2.1.1.4 Хангамж, бараа материалын зардал	13,051.60	480.00
2108	1.1.1.2.1.1.8 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,909.64	1,812.447
2109	1.1.1.2.1.1.9 Бараа үйлчилгээний бусад зардал	25,837.00	281,120.17
213	1.1.1.2.1.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,754.98	14,375.00
2132	1.1.1.2.1.4.2 Бусад урсгал шилжүүлэг	8,754.98	14,375.00
22	<b>1.1.1.2.2 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>161,088.00</b>
2200	1.1.1.2.2.1 Дотоод эх үүсвэрээр	-	161,088.00
4	<b>1.1.1 ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ</b>	<b>17,281.32</b>	<b>18,495.097</b>

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

ТТЗ-ын нэгтгэл хамруулан гүйцэтгэсэн ТТЗ-ын нэгтгэл, ОНХС, ХХС-гийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 67,083.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 13,779.0 мянган төгрөгийн бүртгэл тайлагналын алдаа<sup>1</sup>-г аудитын явцад залруулж, баталгаажуулав. Үүнд:

### Хоршоо хөгжүүлэх сангийн тайланд:

- Санхүү байдлын тайлан, үр дүнгийн тайланг зөрүүтэй илэрхийлсэн – 13,779.0 мянган төгрөг,

Дээрх алдааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.10-д "Аудитын байгууллагаас зөвлөмж болгосон бүртгэлийн алдааны залруулгыг мэргэжлийн түвшинд хянан, удирдлагад танилцуулах, зөвшөөрсөн тохиолдолд тухайн санхүүгийн жил, улирлын тайланд залруулга хийх, зөвшөөрөөгүй тохиолдолд аудиторт үндэслэл бүхий

<sup>1</sup> Мэдээллийг тусгахагүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

тайлбар хүргүүлэх” заалттай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул тайланд залруулсан.

Аудитаар залруулагдаагүй 53,304.0 мянган төгрөгийн материаллаг алдаа нь тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын дүн 28,730.4 мянган төгрөгөөс их, шинж чанарын хувьд материаллаг байгаа тул “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 53,304.0 мянган төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс, 16,000.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 37,304.0 мянган төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өглөө.

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### 3.1 Төлбөрийн акт

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр болох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 9,000.0 мянган төгрөгийг хувь хүний дансаар дамжуулан авч шатахуунд зарцуулсан гэх ч анхан шатны баримтаар нотлогдоогүй хуурамч баримт бүрдүүлэн хувь иргэний данс ашиглан зориулалтын дагуу зарцуулаагүй, мал амьтныг халдварт өвчинтэй тэмцэх хөтөлбөрөөс 7,000.0 мянган төгрөгийг мал амьтны халдварт өвчний устгалд зарцуулсан гэх ч анхан шатны баримтаар нотлогдоогүй хувь иргэний данс ашиглан бэлнээр гаргаж авсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1 -д “Гүйлгээ, үйл ажиллагааг үнэн зөв бүртгэх”, 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3-д “орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно” 60.3.1-д “орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр, арга хэмжээ”, 60.4-д “Энэ хуулийн 60.3.1-д заасан хуулиар тогтоосон чиг үүрэгт тухайн засаг захиргааны нэгжийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэг хамаарахгүй”, 60.3.6-д “орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ”, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

Шийдвэрлэлт: Төлбөрийн акт тогтоосон.

### 3.2 Зөвлөмж

#### 3.2.1 Орон нутгийн хөгжлийн сантай холбоотой асуудал

Илрүүлэлт: Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Грөүт майнд оазис ХХК-тай гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон ч гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй хийсэн ажлын тайлан болон төсвийн задаргаагүй хүрсэн үр дүнг үнэлж тодорхойгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6.орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээг санхүүжүүлэхгүй. Засгийн газрын 2024 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 278 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу санхүүжилтийг олгох” гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

Өгсөн зөвлөмж: Гүйцэтгэлд үндэслэн санхүүжилтийг олгох, гэрээний үүргийн биелэлтийг хангаж ажиллах.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

**3.2.2 Илрүүлэлт:** Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр няравын дансаар болон хувь хүний дансаар дамжуулан хөтөлбөр арга хэмжээнд 10,110.0 мянган төгрөгийг зарцуулсан бөгөөд зарцуулалтын анхан шатны баримт дутуу, хэрхэн зарцуулалт бүрэн бус, мал тооллогоор зарцуулсан шатахууныг орлогод бүртгэж бараа материалын тайланд тусгаагүй 1,815.0 мянган төгрөг зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.6-д “Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна”, 13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”, Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын хоёр дугаар зүйлийн 3-д “Мөнгөний нярав орлого, зарлагын баримтууд, мөнгө олгохыг хүссэн өргөдөл зэргийг үндэслэн баримт тус бүрээр өдөр бүр бэлэн мөнгөн гүйлгээний тайланг 2 хувь үйлдэн, 1 хувийг холбогдох баримтуудын хамт нягтлан бодогчид тушааж, үлдэх хувийг өөртөө үлдээнэ.” гэж заасантай нийцээгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлэн анхан шатны баримтын иж бүрдлийг бүрэн хангаж ажиллах.

**3.2.3 Илрүүлэлт:** Сумын ОНХС, ХХСангийн санхүүгийн тайланд бүртгэлтэй насжилт өндөртэй байгууллагаас болон хувь хүнээс авах авлага 18,779.0 мянган төгрөгийн авлагыг барагдуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-т “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “Төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16 дугаар зүйлийн 16.5.4-д “үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх үүрэгтэй” гэж заасантай, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцээгүй.

**Өгсөн зөвлөмж:** Насжилт өндөртэй авлагыг барагдуулах үе шаттай арга хэмжээ авч ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасны дагуу зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг 2026 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор fas.audit.mn системд тайлагнан ажиллана уу.

Шийдвэрийн хэрэгжилтийг бүрэн хангуулж биелэлтийг Fas.audit.mn цахим системд нотлох баримтын хамт тайлагнан, Ховд аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

##### 4.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдааны утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
								тоо	Дүн	тоо	Дүн		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
Хоршоо хөгжүүлэх сан	Хоршоо хөгжүүлэх сангаас олгосон зээл, зээлийн хүү, алдангийг зөрүүтэй тооцон илэрхийлсэн	1	13,779.00			1	13,779.00	1	13,779.00				
	<b>ДҮН</b>	<b>1</b>	<b>13,779.00</b>			<b>1</b>	<b>13,779.00</b>	<b>1</b>	<b>13,779.00</b>				

##### 4.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн дүн		Үүнээс:							
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сангийн хөтөлбөр болох гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардлаас 9,000.0 мянган төгрөгийг, мал амьтныг халдварт өвчинтэй тэмцэх хөтөлбөрөөс 7,000.0 мянган төгрөгийг мал амьтны халдварт өвчний устгалд зарцуулсан гэх ч анхан шатны баримтаар нотлогдоогүй хувь иргэний данс ашиглан бэлнээр гаргаж авсан	1	16,000.00	1	16,000.00					0	

ОНХС	Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Греүт майнд оазис ХХК-тай гэрээ байгуулан санхүүжилтийг олгосон ч гэрээний хэрэгжилтийг дүгнээгүй хийсэн ажлын тайлан болон төсвийн задаргаагүй хүрсэн үр дүн тодорхойгүй	1	6,600.00					1	6,600.00		
ОНХС	Няравын дансаар болон хувь хүний дансаар дамжуулан хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан ч зарцуулалтын анхан шатны баримт дутуу, хэрхэн зарцуулсан нь тодорхойгүй, мал тооллогоор зарцуулсан шатахууныг орлогод бүртгэж бараа материалын тайланд тусгаагүй	1	11,925.00					1	11,925.00		
ТТЗ	Насжилт өндөртэй авлагыг барагдуулаагүй	1	18,779.00					1	18,779.00		
	<b>ДҮН</b>	<b>4</b>	<b>53,304.00</b>	<b>1</b>	<b>16,000.00</b>	<b>0</b>	<b>-</b>	<b>3</b>	<b>37,304.00</b>	<b>0</b>	<b>-</b>

**5. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл**

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр				
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Зөрчилгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан	
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй					
A	1	2	3	4	5	7	8	9	10	

1	ТШЗ								
2	Төсөл, хөтөлбөр								
3	ЗГТС								
4	ТТЗ	1	1				1		
5	ТЕЗ								
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>				<b>1</b>		